

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэл.....	9
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	10
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	10
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	11
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	11
2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3. Менежментийн захидал .....	12
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	15
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	16
4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	17
4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	18
4.5 Аудит хийсэн зорилтот түвшиний биелэлт .....	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	22

### Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН  
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ”  
ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА О.БАВУУДОРЖ  
ТАНАА

2020.03.13 № 06/847  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон бусад хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага


“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга О.Бавуудорж Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн ашиглагдахгүй байгаа биет бус хөрөнгийг холбогдох газраас зөвшөөрөл авч хасах, санхүүгийн программд хөгжүүлэлт хийх, шилэн дансанд мэдээллийг цаг хугацаанд нь байршуулах, дотоод хяналтыг сайжруулах, батлагдсан орон хэтрүүлэхгүй ажиллах зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн удирдлага Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, компанийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын захиалгаар “Интер аудит” ХХК хийж гүйцэтгэв.

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн №01/83 дугаар бүхий албан бичгээр “Интер аудит” ХХК-д ирүүлсэн.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь “Монгол Улсын зүүн өмнөд бүсийн хөгжлийн хөтөч нь байх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах, хуваарилах үйл ажиллагаа;
- Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар угсралт, туршилт тохируулга, бусад үйлчилгээ

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн цахилгаан түгээх үйлчилгээний төлбөр болон худалдаж авах цахилгааны тарифт гарсан өөрчлөлтийг дараах хүснэгтэд харуулав:

- Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 26, 249, 562 тоот тогтоолуудаар “Диспетчерийн үндэсний төв” ХХК-аас хангах Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн худалдан авах цахилгааны тариф, төлөх түгээх үйлчилгээний төлбөр буюу тарифыг 3 удаа өөрчлөлт оруулсан;
- Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 92, 93, 94 тоот тогтоолуудаар Төв, Зүүн, Өмнөд бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифыг индексжүүлж, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тариф, айл өрхөд борлуулах цахилгааны тариф, тоолуургүй

ахуйн хэрэглэгчдийн цахилгааны төлбөрийг тооцох сарын дундаж цахилгааны хэрэглээнд тус тус 3 удаа өөрчлөлт оруулсан байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус байгууллагын тайлант онд хүчин төгөлдөр мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журмуудтай нийцсэн байна.

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь СТОУС болон Монгол улсын Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуй нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”, “Нягтлан бодох бүртгэлийн дансны жишиг жагсаалт”-д нийцүүлэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр боловсруулан 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “FCS” программ хангамж ашигладаг байна.

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд компанийн нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлагналын ажлын зохион байгуулалт, байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын эрсдэлийн түвшинг “дунд” гэж үзэн суурь үзүүлэлт болох нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь аудитор тогтоосон материаллаг байдлыг тусгайлсан ажил гүйлгээ, дансанд тодруулгуудад хамааралтай эсвэл эрсдэл нь бүхэлдээ санхүүгийн тайлантай хамааралтай эсэхийг авч үзсэнтэй холбоотой юм.

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардал 95,524.1 сая төгрөгөөс 1 хувиар тооцож материаллаг байдлын түвшнийг 955.2 сая төгрөгөөр тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг дахин тооцоолоогүй болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,722.7 сая төгрөгөөр буюу 4.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн данс байна.

### Хүснэгт 2. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	754.8	1,194.8	440.0
Авлага	712.0	448.7	263.3
Бараа материал	959.3	1,404.0	444.7
Үндсэн хөрөнгө	118,695.9	123,797.1	5,101.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>121,122.0</b>	<b>126,844.7</b>	<b>5,722.7</b>
Өр төлбөр	2,461.6	6,434.3	3,972.7
Эздийн өмч	118,660.4	120,410.4	1,750.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>121,122.0</b>	<b>126,844.7</b>	<b>5,722.7</b>

Жилийн эцсийн байдлаар нийт 448.7 сая төгрөгийн авлагатай байгаа ба цахилгаан эрчим хүчний авлага, 358.8 сая төгрөг, Диспетчерийн үндэсний төвөөс авах авлага 30.7 сая төгрөг, хувь хүний орлогын албан татварын авлага 0.2 сая төгрөг, бусад авлага 58.9 сая төгрөг байна.

Авлага дансны үлдэгдэл өнгөрсөн оноос 263.3 сая төгрөгөөр буурсан нь цахилгаан эрчим хүчний авлага 108.7 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татварын авлага 140.7 сая төгрөгөөр буурснаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд он удаан жил болсон байгууллагаас /хувь хүнээс/ авах авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 444.7 сая төгрөгөөр өссөн. Үүнд аваарын нөөц 249.6 сая төгрөгөөр, трансформаторын тос, шатахуун 43.9 сая төгрөгөөр, хангамжийн материал 31.2 сая төгрөгөөр, автын сэлбэг 20.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн. Компанийн үйл ажиллагааг хэвийн, найдвартай явуулахад зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэгийг аюулгүйн нөөцөд худалдан авсан. Бараа материалын үлдэгдэл тайлант өссөнөөр дараагийн тайлант үеийн худалдан авалт буурах нөлөөтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,101.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд их засварын ажилд 510.3 сая төгрөг, техник зохион байгуулалтын арга хэмжээний ажилд 1,150.1 сая төгрөг, хөрөнгө оруулалтын ажилд 4,347.3 сая төгрөг тус тус зарцуулж, Дэлхийн банкны “Эрчим хүчний төсөл-2” төслийн хөрөнгө 371.3 сая төгрөгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2019.02.19-ний өдрийн 48 дугаар тогтоолоор 1,443.0 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авснаас шалтгаалжээ.

Мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019.06.06-ны өдрийн 15 дугаар тогтоолоор 35/6 кВ-ын Цэнхэрмандал дэд станцын 35 кВ системийн өргөтгөл, 35 кВ-ын 45 км урттай ЦДАШ, Жаргалтаан 35/10 кВ-ын 1600 кВА хүчин чадалтай дэд станцын барилга угсралтын ажлыг 3,254.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсний улмаас үндсэн хөрөнгө материаллаг дүнгээр өсөхөд нөлөөлсөн.



Тайлант онд мөн ТӨБЗГ-ын 2019 оны 405 дугаар тогтоолоор 159.0 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг ТӨБЗГ-т үнэ төлбөргүй шилжүүлсэн байна.

ТӨБЗГ-ын 2019 оны 29, 405, 478, 573, 576, 753-р тогтоолууд болон А-1/3804 албан бичгийн дагуу нийт 926.8 сая төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан байна.

Дуусаагүй барилга дансны үлдэгдэл нийт 5,490.7 сая төгрөг. Үүнд:

- Дэлхийн банкны төслийн хүрээнд хийгдэж байгаа ажил 3,350.0 сая төгрөг /үндсэн зээлийн төлбөр 3,058.6 сая төгрөг, хүүгийн зардал 291.4 сая төгрөг/
- Бэрх 110/10кВ дэд станцын барилга угсралтын ажил 1,883.5 сая төгрөг
- Тахилгат 10кВ ЦДАШ 223.1 сая төгрөг
- Багануур ЦТСС-ын Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн барилгын өргөтгөлийн зураг, дүгнэлт 13.8 сая төгрөг

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Эрчим хүчний төсөл-2” төслийн хүрээнд Эрчим хүчний яаман дээр тендер зарлаж гэрээ байгуулагдан ажлууд хийгдэж байгаа бөгөөд гэрээт ажлууд дуусаагүй учраас гэрээний дагуу төлөгдсөн урьдчилгаа болон дундын санхүүжилтийг дуусаагүй барилгад хуримтлуулан бүртгэж, гэрээний ажил дуусахаар хөрөнгөд бүртгэхээр төлөвлөсөн.

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Эрчим хүчний төсөл-2” төсөл нь 2018-2023 оны хооронд хэрэгжиж дуусах бөгөөд төсөл хэрэгжиж дуусах хүртэлх зээлийн хүүгийн зардлыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд хуримтлуулан бүртгэж байгаад төсөл дууссаны дараа капиталжуулна.

Бэрх 110/10кВ дэд станц, Тахилгат 10кВ ЦДАШ-ын барилга угсралтын ажил нь 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлагдсан боловч трансформатор суурилуулах ажил дутуу байгаагаас хөрөнгөд бүртгээгүй, дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй байгаа болно.

Багануур ЦТСС-ын Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн барилгын өргөтгөлийн ажлыг 2020 онд хийхээр төлөвлөсөн бөгөөд өргөтгөл баригдсан үед барилгын зураг, дүгнэлтийн зардлыг хөрөнгөд бүртгэнэ.

Биет бус хөрөнгийн нийт дүн 1,815.7 сая төгрөг байгаагаас газар 1,713.9 сая, программ хангамж 101.8 сая төгрөг байна.

Биет бус хөрөнгийн дүн өнгөрсөн оноос 35.0 сая төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардлын 42.0 сая төгрөг байснаас шалтгаалсан.

Жилийн эцсийн байдлаар нийт 6,434.3 сая төгрөгийн өр төлбөртэй байгаагаас урт хугацаат өр төлбөр 3,500.0 сая, богино хугацаат өр төлбөр 2,934.3 сая төгрөг байна.

Нийт өр төлбөрийн дансны үлдэгдэл 3,972.7 сая төгрөгөөр өссөн нь урт хугацаат өр төлбөр оны эхнээс 3,233.9 сая төгрөгөөр, богино хугацаат өр төлбөр оны эхнээс 737.8 сая төгрөгөөр нэмэгдсэнээс тус тус нөлөөлжээ.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд нэг худалдан авагчид өгөх өглөг 1,597.7 сая төгрөг, бэлтгэн нийлүүлэгчид өгөх өглөг 133.7 сая төгрөг, урт хугацаат өрийн тайлант үеийн өглөг 47.0 сая төгрөг, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын өглөг 1,023.3 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг 3.3 сая төгрөг, цахилгаан эрчим хүчний урьдчилж төлсөн төлбөр 129.4 сая төгрөг тус тус байна.

Богино хугацаат өр төлбөр оны эхнээс 737.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын өглөг 1,023.3 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ. Энэ нь 2018 онд Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 193 тоот тогтоол, Сангийн сайдын 2018 оны 08 сарын 07-ны өдрийн 207 тоот тушаал, Төрийн Өмчийн Бодлого, Зохицуулалтын Газрын 2018 оны 08 сарын 14-ний өдрийн 367 тоот тогтоолын дагуу үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг холбогдох заавар, аргачлалын дагуу хийснээс шалтгаалж санхүүгийн болон татварын зорилгоор байгуулсан элэгдлийн зардлын зөрүүгээр татварын өглөг үүссэний улмаас дээрх дүнгээр богино хугацаат өр төлбөр өссөн байна.

Урт хугацаат өр төлбөр оны эхнээс 3,233.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Дэлхийн банкны “Эрчим хүчний төсөл-2” төслийн зээл, зээлийн хүүгийн өглөг 3,234.5 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан.

Эздийн өмч дансны үлдэгдэл 120,410.4 сая төгрөг болж, 1,750.0 сая төгрөгөөр өссөн нь эздийн өмчийн бусад хэсэг 1,092.8 сая төрөг, хуримтлагдсан ашиг 676.8 сая төгрөг болж өссөнөөс шалтгаалжээ.

Эздийн өмчийн бусад хэсэг 1,092.8 сая төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2019 оны 48 дугаар тогтоолоор Дорноговь аймгийн Иххэт сумын 6 кВ-ын ЦДАШ, уурын зуухны барилга, 6/0.4 кВ, 10/0.4 кВ-ын тоноглол, трансформатор, Сайхандулаан, Хатанбулаг, Мандах сумдын 0.4 кВ-ын ЦДАШ, СИП утас, тоолуур нэгтгэсэн шит 1,443.0 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансанд шилжүүлэн үндсэн хөрөнгөд бүртгэж авснаас шалтгаалжээ.

## 2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэл

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны “Компанийн 2019 үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг батлах тухай” 01 тогтоолоор 2019 оны зорилтот түвшнийг баталсан байна. Мөн 2019 оны 10-р сарын 14-ний Төлөөлөн Удирдах Зөвлөлийн “Компанийн 2019 эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний тодотгосон төлөвлөгөөг батлах тухай” 26 тогтоолоор “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2019 оны зорилтот түвшнийг өөрчлөлт оруулан тодотгосон байна. Тайлант онд 87,602.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 87,263.4 сая төгрөгийн зардалтай, 338.9 сая төгрөгийн ашигтай ажиллахаар батлагджээ.

Нийт 97,157.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөнөөс 9,555.5 сая төгрөгөөр давсан нь тайлант үед “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-с цахилгаан эрчим хүч худалдан авах хэрэглэгчдийн хэрэглээ 42.7 сая кВт\*ц-аар давснаас шалтгаалжээ.

Нийт 95,553.5 сая төгрөгийн зардалтай ажиллаж, төлөвлөгөөнөөс 8,290.1 сая төгрөгөөр илүү, зарцуулсан нь худалдан авсан цахилгаан эрчим хүчний зардал 8,296.2 сая төгрөгөөр хэтэрч, түгээх үйл ажиллагааны зардлыг 316.4 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Батлагдсан орон тоо 530, гүйцэтгэлээр удирдлага 5, инженер техникийн ажилтан, албан хаагч 196, ажилчид 332, нийт 533 орон тоотой ажиллаж, батлагдсан орон тоог 3-аар, нийт цалингийн сангийн зардлыг төлөвлөгөөнөөс 23.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Ингэхдээ, дараах гурван албан тушаал дээр доорх үндэслэлээр 3 орон тоон дээр хүн нэмж ажиллуулсан байна:

- Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Эрчим хүчний төсөл-2” төслийн хүрээнд борлуулалт-арилжааны программыг шинээр худалдан авч, харьяа салбаруудад шинээр сервер зохион байгуулж мэдээллийн санг үүсгэх, түүний аюулгүй ажиллагааг хангах, хэрэглэгчдийн тоолууруудыг ухаалаг тоолуур болгохтой холбоотой аюулгүй ажиллагааг

хангах зэрэг зайлшгүй ажлын шаардлагаар Мэдээлэл технологийн албанд мэдээллийн аюулгүй байдал, өгөгдлийн сан хариуцсан инженер.

- Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлын хэмжээ 2018 онд 2586.1 сая төгрөг байсан бол 2019 онд 9130.1 сая төгрөг буюу 3.5 дахин нэмэгдсэнээс шалтгаалж худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтнуудын ажлын ачаалал эрс нэмэгдсэн гэх шалтгаанаар Худалдан авах ажиллагаа, хангамжийн албанд гэрээ, үнэлгээний мэргэжилтэн.
- Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлын хэмжээ нэмэгдсэнтэй холбогдуулан төсөв, зураг гаргах, гүйцэтгэлийг шалгаж хүлээн авах ажлын ачаалал эрс нэмэгдсэн тул Түгээх үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэст засвар, зургийн инженер.

Эрчим хүчний Яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Эрчим хүчний зохицуулах хороо, компанийн Төлөөлөн удирдах зөвлөл-өөс компанийн 2020 оны бүтэц, орон тоог хянаж, компанийн 2020 эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг батлахдаа орон тоог 20-оор нэмэгдүүлж 550 орон тоотой ажиллахаар баталсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан бүтэц, орон тоонд дээрх 3 орон тоог шинээр нэмж баталсан байна

Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал нийт 1,604.2 сая төгрөгийн ашигтай, татвар төлсний дараа 657.9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, борлуулалтын 1 төгрөгт 0.98 мөнгөний зардалтай ажиллаж, төлөвлөгөөнөөс 0.03 мөнгөөр хэмнэсэн үзүүлэлттэй байна.

## **2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож зөвлөмж өглөө.

Аудитаар илрүүлсэн нийт 74.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 367 дугаар тогтоолоор “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд 18,535,498,517.37 (арван найман тэр бум таван зуун гучин таван сая дөрвөн зүүн ерэн найман мянга таван зуун арван долоон төгрөг гучин долоон мөнгө) төгрөгийн өртөг бүхий Дорноговь аймгийн Замын-Үүдийн Чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн барилга байгууламжийг бүртгэх шийдвэр гарсан. Гэвч уг хөрөнгийн үнэлгээг зах зээлийн үнээс хэт өндөр байгаа тул үнэлгээ хийлгэн бодит үнэ цэнээр нь бүртгэх хүсэлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2019 оны 12 дугаар 31-ний өдөр хүргүүлсэн. Уг хүсэлтийн хариуд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 2020 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн А-1/64 дугаар албан бичгээр хариу ирүүлсэн ба өмнөх тогтоолын дүнгээр бүртгэх чиглэлийг өгсөн. Уг хөрөнгөтэй холбоотой бүртгэлийг дараагийн тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитаар анхаарах шаардлагатай гэж үзлээ.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь 2019 оны зорилтот түвшин, бизнесийн төлөвлөгөөнд тусгагдсан мөнгөн урсгал, орлого, зардал, удирдлагын шийдвэр, санхүүжилт, тендер шалгаруулалт, худалдан авалт, тохиолдсон голлох үйл явдал, онцлог ажил гүйлгээний талаарх мэдээллийг <http://shilendans.gov.mn/org/5167> сайтад оруулж олон нийтэд толилуулж байна.

Шилэн дансны цахим системд оруулсан Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн тайлангийн гэрээний дүнг буруу тайлагнаж, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" зарчмыг зөрчсөн. Мөн Эрчим хүчний яаманд тайлагнадаг Гүйцэтгэлийн мэдээг алдаатай тайлагнасан байна.

## **2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгснийг 2019 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт

Аудитаар залруулагдаагүй 74.9 сая төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон 955.2 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1. Биет бус хөрөнгийн талаар**

##### **3.1.1. Илрүүлэлт:**

Байгууллагад бүртгэлтэй нийт 21 биет бус хөрөнгө байгаагаас 41.7 сая төгрөгийн анхны өртөгтэй нийт 12 биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссан байна. Ашиглалтын хугацаа нь дууссан эдгээр биет бус хөрөнгүүдийн заримыг нь үйл ажиллагаандаа ашигласаар байгаа боловч дахин үнэлж бүртгэлд тусгаагүй нь НББОУС 38 Биет бус хөрөнгө, СТОУС-ын Үзэл баримтлалын шаардлагуудад нийцээгүйгээс гадна үнэлгээ, хэмжилт, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

##### **3.1.2. Эрсдэл:**

Аж ахуйн нэгжид хамааралтай НББОУС-ын стандартууд мөрдөгдөхгүй байх.

##### **3.1.3. Өгсөн зөвлөмж:**

Ашиглалтын хугацаа нь дууссан, үйл ажиллагаандаа ашиглахгүй байгаа биет бус хөрөнгүүдийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авч актлах. Ашиглалтын хугацаа нь дууссан хэдий ч ашиглаж байгаа биет бус хөрөнгүүдийг СТОУС 13 Бодит үнэ цэнийн хэмжилт, НББОУС 38 Биет бус хөрөнгө, СТОУС-ын Үзэл баримтлалын дагуу дахин үнэлж бүртгэлд тусгах.

##### **3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

### **3.2. Санхүүгийн программын талаар**

#### **3.2.1. Илрүүлэлт:**

Байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэхдээ ашиглаж буй FCS санхүүгийн программ нь Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнгээс санхүүгийн программуудад хийсэн үнэлгээнд хамрагдаагүй, мөн холбогдох шалгууруудыг хангаагүй байна. Үүнээс гадна уг санхүүгийн программ нь Сангийн яам, Төрийн аудитын байгууллага, татварын байгууллага, Нийгмийн даатгалын байгууллага, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Шилэн дансны системүүдтэй мэдээлэл цахимаар солилцох боломжгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11-д заасны дагуу уг программ нь Сангийн яамнаас аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлагыг хангасан санхүүгийн программуудын жагсаалтад байхгүй бөгөөд толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **3.2.2. Эрсдэл:**

Санхүүгийн программаас гарч буй мэдээлэл алдаатай байх, цахим системүүдэд мэдээлэл буруу орох, мэдээлэл солилцоход цаг хугацаа алдах.

#### **3.2.3. Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлдээ Сангийн яамнаас итгэмжлэгдсэн санхүүгийн программ хэрэглэх. Ингэхдээ холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын зүгээс тавьж буй санхүүгийн программын шаардлагуудад нийцсэн байх.

#### **3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

### **3.3. Байгууллагын дотоод хяналтын талаар**

#### **3.3.1. Илрүүлэлт:**

Тайлант онд Дотоод хяналтын алба нь 4 хүний бүрэлдэхүүнтэй ажиллахаар орон тоо батлагдсан боловч 2019 оны 2-р сард жирэмсний амралтаа авсан хүний оронд орсон хүн нь 2019 оны 3-р сард ажлаасаа буцаж гарсны улмаас тайлант онд бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаагүйн улмаас дотоод хяналтын ажил хангалтгүй байсан.

#### **3.3.2. Эрсдэл:**

Байгууллагын үйл ажиллагаанд тавигдах дотоод хяналт сулрах, холбогдох эрсдэлүүд үүсэх.

#### **3.3.3. Өгсөн зөвлөмж:**

Батлагдсан орон тооны дагуу ажиллаж, дотоод хяналтыг сайжруулах.

#### **3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

### **3.4. Шилэн дансны мэдээллийн талаар**

#### **3.4.1. Илрүүлэлт:**

Шилэн дансны цахим системд оруулсан Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн тайлангийн гэрээний дүнг буруу тайлагнаж, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр

зүйлийн 4.1.1-д заасан "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" зарчимтай нийцэхгүй, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **3.4.2. Эрсдэл:**

Шилэн дансны тухай хууль зөрчигдөх, мэдээлэл алдаатай тайлагнагдах.

#### **3.4.3. Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" зарчмын дагуу худалдан авах ажиллагааны мэдээллийг үнэн зөв толилуулах.

#### **3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

### **3.5. Орон тооны асуудлаар**

#### **3.5.1. Илрүүлэлт:**

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 30 дугаар тогтоолоор 2019 онд 530 хүнтэй ажиллахаар бүтэц, орон тоог баталж өгсөн. Харин тайлант үед Дэлхийн банкны төслийн хөрөнгө оруулалтын ажлууд хэрэгжиж эхэлсэн, 2019 оны тодотгосон төлөвлөгөөгөөр их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажил 3.5 дахин нэмэгдсэний улмаас 533 хүний бүтэц, орон тоотой ажиллаж орон тоог 3-аар хэтрүүлж ажилласан байна.

#### **3.5.2. Эрсдэл:**

Батлагдсан орон тоонд төсөвлөсөн цалингийн сан хэтрэх.

#### **3.5.3. Өгсөн зөвлөмж:**

Эрчим хүчний яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Эрчим хүчний зохицуулах хороо, компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь компани дээр нэмэгдүүлэх шаардлагатай бүтэц, орон тооны асуудлыг шийдвэрлэх, гүйцэтгэх удирдлага батлагдсан бүтэц, орон тоог мөрдөж ажиллах.

#### **3.5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	754,833,710.42	1,194,842,456.33
Дансны авлага	467,635,104.50	389,568,226.91
Татвар, НДШ-ийн авлага	220,738,216.69	190,952.00
Бусад авлага	23,593,306.90	58,929,308.49
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
Бараа материал	915,690,500.76	1,382,077,042.22
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	-	-
Бусад эргэлтийн хөрөнгө	43,634,000.00	21,932,000.00
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2,426,124,839.27</b>	<b>3,047,539,985.95</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	116,820,371,156.14	121,669,573,949.72
Биет бус хөрөнгө	1,850,746,161.92	1,815,744,695.76
Хойшлогдсон татварын хөрөнгө	24,757,324.60	311,822,239.05
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>118,695,874,642.66</b>	<b>123,797,140,884.53</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>121,121,999,481.93</b>	<b>126,844,680,870.48</b>
<b>Өр төлбөр</b>		
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
Дансны өглөг	1,964,357,765.18	1,597,675,390.24
Татварын өглөг	115,871.00	1,026,590,011.36
Банкны богино хугацаат зээл		
Урьдчилж орсон орлого	94,772,671.88	129,360,655.79
Бусад богино хугацаат өр төлбөр	27,708,792.75	133,655,923.27
Урт хугацаат өрийн тайлант үеийн өглөг	108,560,257.06	47,011,247.71
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>2,195,515,357.87</b>	<b>2,934,293,228.37</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
Урт хугацаат зээл	266,103,303.47	3,499,983,675.86
Бусад урт хугацаат өр төлбөр		
Хойшлогдсон татварын өглөг		
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>266,103,303.47</b>	<b>3,499,983,675.86</b>
<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>2,461,618,661.34</b>	<b>6,434,276,904.23</b>
<b>Эзэмшигчдийн өмч ба капитал</b>		
Төрийн өмч	33,766,009,000.00	33,766,009,000.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	79,713,939,127.04	79,694,305,494.68
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	1,843,205,083.61	2,936,048,111.29
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	3,337,227,609.94	4,014,041,360.28
Тайлант үеийн		
Өмнөх үеийн		
<b>Эзэмшигчдийн өмч ба капиталын дүн</b>	<b>118,660,380,820.59</b>	<b>120,410,403,966.25</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН</b>	<b>121,121,999,481.93</b>	<b>126,844,680,870.48</b>



## 4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого /цэвэр/	74,870,722,842.94	95,266,629,363.49
Борлуулалтын өртөг	71,548,858,672.07	91,126,701,221.71
<b>Нийт ашиг /алдагдал/</b>	<b>3,321,864,170.87</b>	<b>4,139,928,141.78</b>
Түрээсийн орлого		
Хүүгийн орлого	68,929,828.51	89,637,835.13
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого	710,292,419.29	1,772,026,375.83
Борлуулалт, маркетингийн зардал	2,763,255,611.63	2,882,742,742.93
Ерөнхий ба удирдлагын зардал	562,438,593.59	625,876,098.80
Санхүүгийн зардал		
Бусад зардал	451,197,561.28	389,268,956.74
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз /гарз/		-57,875,141.36
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	-201,075,914.68	-441,608,204.31
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Хөрөнгө оруулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)		
Бусад ашиг ( алдагдал)		
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал)</b>	<b>123,118,737.49</b>	<b>1,604,221,208.6</b>
Орлогын татварын зардал	118,403,102.11	946,333,745.33
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>4,715,635.38</b>	<b>657,887,463.27</b>
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>4,715,635.38</b>	<b>657,887,463.27</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
<b>Орлогын нийт дүн</b>		
<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

### 4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
<b>2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>27,073,643,900.00</b>	<b>7,096,603,438.25</b>	<b>6,692,365,183.61</b>	<b>3,728,561,865.64</b>	<b>44,591,174,387.50</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-72,894,328.60	<b>-72,894,328.60</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>27,073,643,900.00</b>	<b>7,096,603,438.25</b>	<b>6,692,365,183.61</b>	<b>3,655,667,537.04</b>	<b>44,518,280,058.90</b>
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал				4,715,635.38	<b>4,715,635.38</b>
Бусад дэлгэрэнгүй орлого			1,843,205,000.00		<b>1,843,205,000.00</b>
Өмчид гарсан өөрчлөлт	<b>6,692,365,100.00</b>		-6,692,365,100.00		<b>0.00</b>
Зарласан ногдол ашиг				-338,066,630.00	<b>-338,066,630.00</b>
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		72,617,335,688.79		14,911,067.52	<b>72,632,246,756.31</b>
<b>2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>33,766,009,000.00</b>	<b>79,713,939,127.04</b>	<b>1,843,205,083.61</b>	<b>3,337,227,609.94</b>	<b>118,660,380,820.59</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				0.02	<b>0.02</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>33,766,009,000.00</b>	<b>79,713,939,127.04</b>	<b>1,843,205,083.61</b>	<b>3,337,227,609.96</b>	<b>118,660,380,820.61</b>
Тайлант үеийн ашиг, алдагдал				657,887,463.27	<b>657,887,463.27</b>
Бусад дэлгэрэнгүй орлого			1,092,843,027.68		<b>1,092,843,027.68</b>
Өмчид гарсан өөрчлөлт					
Зарласан ногдол ашиг				-707,345.31	<b>-707,345.31</b>
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-19,633,632.36		19,633,632.36	<b>-</b>
<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>33,766,009,000.00</b>	<b>79,694,305,494.68</b>	<b>2,936,048,111.29</b>	<b>4,014,041,360.28</b>	<b>120,410,403,966.25</b>

#### 4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>58,167,334,051.06</b>	<b>73,243,228,647.92</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	57,198,547,284.75	71,271,480,029.37
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	74,934,738.00	93,305,770.00
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	893,852,028.31	1,878,442,848.55
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>54,619,250,909.65</b>	<b>64,988,642,295.96</b>
Ажиллагчдад төлсөн	8,531,129,461.37	9,270,435,389.88
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,322,749,492.37	2,627,126,513.66
Бараа материал худалдан авахад төлсөн	38,949,228,147.01	46,339,767,568.50
Ашиглалтын зардалд төлсөн	435,061,279.51	401,541,318.89
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	598,730,383.76	995,134,433.15
Хүүний төлбөрт төлсөн	239,285.34	245,032,234.70
Татварын байгууллагад төлсөн	2,591,548,949.72	3,209,327,687.50
Даатгалын төлбөрт төлсөн	55,538,861.45	31,411,240.13
Бусад мөнгөн зарлага	1,135,025,049.12	1,868,865,909.55
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>3,548,083,141.41</b>	<b>8,254,586,351.96</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>68,228,723.85</b>	<b>89,600,317.32</b>
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого	68,228,723.85	89,600,317.32
Хүлээн авсан ногдол ашиг		
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>2,823,169,149.85</b>	<b>7,902,396,872.00</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,823,169,149.85	7,902,396,872.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2019 оны  
санхүүгийн тайлангийн аудит

Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-2,754,940,426.00</b>	<b>-7,812,796,554.68</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,190,268,285.00</b>	<b>518,016,583.00</b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,190,268,285.00	518,016,583.00
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>1,529,408,621.06</b>	<b>519,797,634.37</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	1,191,341,991.06	519,090,289.06
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
Төлсөн ногдол ашиг	338,066,630.00	707,345.31
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-339,140,336.06</b>	<b>-1,781,051.37</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>454,002,379.35</b>	<b>440,008,745.91</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>300,831,331.07</b>	<b>754,833,710.42</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>754,833,710.42</b>	<b>1,194,842,456.33</b>

#### 4.5 Аудит хийсэн зорилтот түвшиний биелэлт

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/сая төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Худалдан авсан ЦЭХ	сая кВт*ц	414.8	457.4	42.6	110.3
	үүнээс: Импортын ЦЭХ	сая кВт*ц	0.669	0.596	-0.1	89.1
2	Түгээлтийн алдагдал хувиар	хувь	8.60%	7.79%	-0.80%	90.7
	биетээр	сая кВт*ц	35.6	35.7	0.1	100.2
3	Борлуулсан ЦЭХ	сая кВт*ц	379.2	421.8	42.6	111.2
	үүнээс: импортын борлуулах ЦЭХ	сая кВт*ц	0.586	0.509	-0.1	86.8
	Борлуулалтын дундаж үнэ	төг/кВт*ц	176.21	175.84	-0.37	99.8
4	<b>Нийт орлого</b>	сая төг	<b>87,602.3</b>	<b>97,157.8</b>	<b>9,555.5</b>	<b>110.9</b>
	Үүнээс: Борлуулалтын орлого	сая төг	66,812.9	74,161.1	7,348.1	111.0
	Түгээх үйлчилгээний орлого	сая төг	19,551.7	21,005.0	1,453.3	107.4
	Импортын эрчим хүчний орлого	сая төг	125.8	100.5	-25.3	100.0
	Үйл ажиллагааны бус орлого	сая төг	1,111.9	1,891.1	779.3	170.1
5	<b>Нийт зардал</b>	сая төг	<b>87,263.5</b>	<b>95,553.5</b>	<b>8,290.1</b>	<b>109.5</b>
	Үүнээс:Худалдан авсан эрчим хүчний зардал	сая төг	63,563.8	71,860.0	8,296.2	113.1
	ХУА ЦЭХ-ний тариф	төг/кВт*ц	153.23	157.10	3.87	102.5
	Түгээх ажиллагааны зардал	сая төг	22,944.4	22,628.0	-316.4	98.6
	Импортын эрчим хүчний зардал	сая төг	205.3	147.4	-58.0	100.0
	Үйл ажиллагааны бус зардал	сая төг	549.9	918.2	368.3	167.0
6	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал</b>	сая төг	<b>338.8</b>	<b>1,604.2</b>	<b>1265.4</b>	<b>473.5</b>
	Орлогын албан татвар	сая төг	33.9	946.3	912.5	0.0
	Цэвэр ашиг, алдагдал	сая төг	<b>304.9</b>	<b>657.9</b>	352.9	215.7
7	<b>Төрийн өмчийн ногдол ашиг</b>	сая төг	<b>0.0</b>	<b>707.3</b>	<b>707.3</b>	<b>0.0</b>
8	<b>Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал</b>	төг	<b>1.00</b>	<b>0.98</b>	<b>-0.01</b>	<b>98.7</b>
9	<b>Нийт авлага</b>	сая төг	<b>1,080.0</b>	<b>448.7</b>	<b>-631.3</b>	<b>41.5</b>
	Үүнээс: ЦЭХ-ний авлага	сая төг	1,080.0	358.8	-721.2	33.2
	ДҮТ-ийн авлага	сая төг	0.0	30.7	30.7	0.0
	НӨАТ-ын авлага	сая төг	0.0	0.0	0.0	0.0
	ХАОАТ-ын авлага	сая төг	0.0	0.2	0.2	100.0
	Бусад авлага	сая төг	0.0	58.9	58.9	0.0
10	<b>Нийт өр төлбөр</b>	сая төг	<b>10,493.5</b>	<b>6,434.3</b>	<b>-4,059.2</b>	<b>61.3</b>
	Урт хугацаат өр төлбөр	сая төг	<b>8,217.8</b>	<b>3,500.0</b>	-4,717.8	42.6
	Богино хугацаат өр төлбөр	сая төг	<b>2,275.7</b>	<b>2,934.3</b>	658.6	128.9
	Үүнээс: НХА-ийн өглөг	сая төг	2,155.7	1,597.7	-558.0	74.1

**“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2019 оны  
санхүүгийн тайлангийн аудит**

	БН-ийн өглөг	сая төг	0.0	133.7	133.7	0.0
	ДҮТ-ийн өглөг	сая төг	0.0	0.0	0.0	0.0
	Урт хугацаат өрийн тайлант үеийн өглөг	сая төг	0.0	47.0	47.0	0.0
	ААНОАТ өглөг	сая төг	0.0	1,023.3	1,023.3	100.0
	НӨАТ-ын өглөг	сая төг	0.0	3.3	3.3	200.0
	ЦЭХ-ний УТТ	сая төг	120.0	129.4	9.4	107.8
11	<b>Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ</b>	сая төг	<b>9,130.1</b>	<b>8,694.5</b>	<b>-435.6</b>	<b>95.2</b>
Үүнээс	Хөрөнгө оруулалт	сая төг	7,292.7	6,907.4	-385.3	94.7
	Их засвар	сая төг	584.9	565.5	-19.4	96.7
	ТЗБАХ	сая төг	1,252.5	1,221.6	-30.9	97.5
12	<b>Нийт ажиллагсдын тоо</b>	хүн	<b>530</b>	<b>533</b>	<b>3</b>	<b>100.5</b>
	<b>Нийт цалингийн сан</b>	сая төг	<b>9,382.9</b>	<b>9,406.1</b>	<b>23.2</b>	<b>100.2</b>
13	<b>Нэг ажилтны дундаж цалин</b>	мян.төг	<b>1,475.3</b>	<b>1,472.0</b>	<b>-3.3</b>	<b>99.8</b>

### 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020.03.10	Аудитын нэр:	2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан	Аудитын код:
				САГ-2020/101/СТА-ТӨХК
Шалгагдсан байгууллагын нэр:	“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК			Сая төгрөгөөр

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Байгууллагад бүртгэлтэй нийт 21 биет бус хөрөнгө байгаагаас 41.7 сая төгрөгийн анхны өртөгтэй нийт 12 биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссан байна. Ашиглалтын хугацаа нь дууссан эдгээр биет бус хөрөнгүүдийн заримыг нь үйл ажиллагаандаа ашигласаар байгаа боловч дахин үнэлж бүртгэлд тусгаагүй нь НББОУС 38 Биет бус хөрөнгө, СТОУС-ын Үзэл баримтлалын шаардлагуудад нийцээгүйгээс гадна үнэлгээ, хэмжилт, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.	41.7	Зөвлөмж	Ерөнхий нягтлан бодогч	Т.Болдсанаа
Байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэхдээ ашиглаж буй FCS санхүүгийн программ нь Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнгээс санхүүгийн программуудад хийсэн үнэлгээнд хамрагдаагүй, мөн холбогдох шалгууруудыг хангаагүй байна. Үүнээс гадна уг санхүүгийн программ нь Сангийн яам, Төрийн аудитын байгууллага, татварын байгууллага, Нийгмийн даатгалын байгууллага, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Шилэн дансны системүүдтэй мэдээлэл цахимаар солилцох боломжгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11-д заасны дагуу уг программ нь Сангийн яамнаас аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлагыг хангасан санхүүгийн программуудын жагсаалтад байхгүй бөгөөд толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.	10.0	Зөвлөмж	Ерөнхий нягтлан бодогч	Т.Болдсанаа

<p>Тайлант онд Дотоод хяналтын алба нь 4 хүний бүрэлдэхүүнтэй ажиллахаар орон тоо батлагдсан боловч 2019 оны 2-р сард жирэмсний амралтаа авсан хүний оронд орсон хүн нь 2019 оны 3-р сард ажлаасаа буцаж гарсны улмаас тайлант онд бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаагүйн улмаас дотоод хяналтын ажил хангалтгүй байсан.</p>	-	Зөвлөмж	Дотоод хяналтын хэлтсийн дарга	С.Сэрээтэр
<p>Шилэн дансны цахим системд оруулсан Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн тайлангийн гэрээний дүнг буруу тайлагнаж, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" зарчимтай нийцэхгүй, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.</p>	-	Зөвлөмж	Худалдан авах ажиллагаа, хангамжийн хэлтсийн дарга	П.Ганбаяр
<p>Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 30 дугаар тогтоолоор 2019 онд 530 хүнтэй ажиллахаар бүтэц, орон тоог баталж өгсөн. Харин тайлант үед Дэлхийн банкны төслийн хөрөнгө оруулалтын ажлууд хэрэгжиж эхэлсэн, 2019 оны тодотгосон төлөвлөгөөгөөр их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажил 3.5 дахин нэмэгдсэний улмаас 533 хүний бүтэц, орон тоотой ажиллаж орон тоог 3-аар хэтрүүлж ажилласан байна.</p>	23.2	Зөвлөмж	Гүйцэтгэх захирал	Н.Тавинбэх
<b>Нийт дүн</b>	<b>74.9</b>			